

## **Оруулсан огноо: 2022 оны 06 дүгээр сарын 30-ны өдөр**

Сонгон шалгаруулалтын нэр: “Өргөө амаржих газар” ТМЭ-ийн цайны газрын талбайг /тоног төхөөрөмжгүй/ түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах.

Төрийн өмчийн хорооны 2020 оны 02-р сарын 18-ны өдрийн дугаар 49 дүгээр тогтоолоор батлагдсан “**Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам**”-ыг үндэслэн “Өргөө амаржих газар” ТМЭ-д цайны газрын талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Шалгаруулалтад оролцогч хуулийн этгээд нь **2022 оны 07 дугаар 07-ны өдрийн 10:00** цагаас өмнө “Өргөө амаржих газар”ТМЭ-д материалаа битүүмжлэн ирүүлсэн байна.

Ирүүлэх материалдаа дараах зүйлсийг тодорхой тусгасан байна. Үүнд:

1. Хуулийн этгээд нь “Өргөө амаржих газар”ТМЭ-ийн Удирдлагууд, Санхүү хариуцсан албан тушаалтнуудтай ашиг сонирхлын зөрчилгүй, хамаарал бүхий нэгдмэл сонирхолтой этгээд биш болохыг мэдэгдэх тодорхойлолт ирүүлэх.
2. Цайны газрын үйл ажиллагааг эрхлэн ажиллах боловсон хүчний тодорхойлолт, мэргэжлийн үнэмлэхний хуулбарыг нотариатаар батлуулсан байх. Хоол зүйч эсвэл нийтийн хоолны технологич аль нэг нь заавал байх шаардлагатай.
3. Хоолны үнийн санал болон танилцуулгыг үлгэрчилсэн цэс байдлаар ирүүлэх.
4. Цайны газрыг түрээслэх үнийн саналаа ирүүлэх. Ашиглалтын зардал ороогүй дүнгээр 1м<sup>2</sup> талбайн түрээсийн доод үнийн дүн 10,000 төгрөг байна.
5. Түрээсийн төлбөрөө 3 /Гурав/ сараар урьдчилан төлөх санхүүгийн чадвартай, хөрөнгийн баталгаатай байх. (Холбогдох эрх бүхий байгууллагын баталгаа гаргуулах.)
6. Шүүхийн шийдвэрээр өргүй талаарх тодорхойлолт.

### **Түрээслэх талбайн талаарх товч танилцуулга:**

№	Түрээслэхээр санал болгож буй талбайн зориулалт	Талбайн хэмжээ /м.кв/	Түрээслэх үний доод хэмжээ	талбайн байршил
1	Цайны газрын зориулалтай /тоног төхөөрөмжгүй/	108м <sup>2</sup>	10,000₮	ӨАГТМЭ-ийн өргөтгөлийн 1 давхар

**Жич:** Түрээслэх үнэнд цахилгаан, дулаан, усны төлбөрийн үнэ ороогүй болно.

### **Хавсралт-1**

**Түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах худалдаа үйлчилгээнд тавигдах шаардлага:**

№	Үйлчилгээний чиглэл	Үндсэн шаардлага	ӨАГТМЭ-ийн тавигдах шаардлага
---	---------------------	------------------	-------------------------------

1	Цайны газар	<ul style="list-style-type: none"> <li>✓ Аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй байх</li> <li>✓ Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэй байх.</li> <li>✓ Үйл ажиллагааны үндсэн стандарт хангасан байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>I. ӨАГТМЭ-ийн албан хаагчдад хөнгөлөлттэй үнээр, түргэн шуурхай, чанартай, эрүүл халуун хоол цайгаар үйлчилнэ.</li> <li>II. ААН нь цайны газрын чиглэлээр 2-аас дээш жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байх. /үйл ажиллагааны тайланг ирүүлэх/</li> <li>III. Ажилчдад зориулж сэт хоолны меню гаргах.</li> <li>IV. Сэт хоолны үнийн санал ирүүлэх</li> </ul>
---	-------------	--	---

Сонгон шалгаруулах комисс нь “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу шалгаруулалтад оролцогчдын материалыг **2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 10:00 цаг** хүртэл хүлээн авч, шалгаруулалтыг хуулийн дагуу явуулж “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ”-г байгуулна.

**Шаардлагатай мэдээллийг доорх хаягаар авч болно.**

**Хаяг:** СБД 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, автозамчдын гудамж

Захиргааны хаалга 111 тоот

**Харилцах утас:** 97187777, 77000101